



X-XII/2021

Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 14




Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 1.0 хувиар өссөн байна

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 4 дүгээр улиралд 129.8 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурсан байна. Харин өмнөх улирлаас 1.0 хувиар өссөн байна.

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 4 дүгээр улиралд 109.5 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 2.6 хувь, өмнөх улирлаас 0.5 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар



2018				2019				2020				2021			
I-III	IV-VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI	VII-IX	X-XII	I-III	IV-VI	VII-IX	X-XII

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 1.0 хувиар өсөхөд богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 1.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Түүнчлэн аймгуудын зочид буудлын үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ 6.1 хувь, нийслэл 0.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 X-XII	2021 X-XII	2021 X-XII
	2015	2020 X-XII	2021 VII-IX
	2015=100		
Ерөнхий индекс	129.8	99.2	101.0
Богино хугацаагаар байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	129.5	99.1	101.0
Автомашин зогсоол бүхий зуслан, чөлөөт цаг өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа	161.7	100.8	100.0
Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа	101.4	103.5	101.7

ХҮСНЭГТ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	2021 X-XII	2021 X-XII	2021 X-XII
	2015	2020 X-XII	2021 VII-IX
	2015=100		
Ерөнхий индекс	129.8	99.2	101.0
Нийслэл	129.1	98.3	100.3
Аймаг	135.3	106.2	106.1

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 0.5 хувиар өсөхөд аймгийн нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ 2.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	2021 X-XII	2021 X-XII	2021 X-XII
	2015	2020 X-XII	2021 VII-IX
	2015=100		
Ерөнхий индекс	109.5	102.6	100.5
Нийслэл	108.7	101.9	100.2
Аймаг	115.5	107.0	102.8

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс: Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал: Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

I_p^t – t тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

t – тайлант үе

0 – суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i – i барааны суурь үеийн худалдан авсан тоо



Эх үүсвэр:

ҮСХ, Зочид буудал, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал,
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Мөнхтуул
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212